



ЦУС СЭЛБЭЛТ СУДААЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

ᠴᠤᠰ ᠰᠡᠯᠪᠡᠯᠲᠤ ᠰᠤᠳᠤᠯᠠᠯᠠ ᠶᠢᠨ ᠤᠨᠳᠡᠰᠨᠢ ᠲᠡᠪ

Эмнэлгийн цус сэлбэлтийг зохицуулах зөвлөл

Н.Эрдэнэбаяр
АУ-ны доктор, дэд профессор
ЦССҮТ-ийн захирал

УБ хот, Сүхбаатар дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө-13, ЦССҮТ
Утас/Факс: 976-70112857, Э-шуудан: nctmmgl@gmail.com

- ДЭМБ-ын зөвлөмж
- Цусыг зохистой хэрэглэх ДЭМБ-ын стратеги
- Эмнэлгийн цус сэлбэлтийг зохицуулах зөвлөлийн зорилго, үйл ажиллагаа
- Бүтэц, бүрэлдэхүүн
- ЦССЗ эрх үүрэг
- Цусны нөөц зохицуулах нэгж
- Цусны нөөц зохицуулах нэгжийн эрх үүрэг

Цус сэлбэлтийг зохицуулах зөвлөл нь:

- Үндэсний бодлого, ЦЦБ-ийг зохистой хэрэглэх удирдамжийг хэрэгжүүлэх, ЦЦБ-ийг хэрхэн хэрэглэж байгаад хяналт тавих зорилготой.
- Эмнэлэг дээрээ цус сэлбэлтийн талаар баримтлах бодлогоо тодорхойлж, тулгамдсан асуудлаа шийдвэрлэх, цусны аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа явуулна.


Цусыг зохистой хэрэглэх стратеги



ЦСЗЗ үйл ажиллагаа

Цус сэлбэлтийг зохицуулах зөвлөл (ЦСЗЗ) нь тухайн эрүүл мэндийн байгууллагад цусны аюулгүй байдлыг хангах болон цус, цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээг хэвшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

ЦСЗЗ-ийн бүрэлдэхүүн





Эрүүл мэндийн байгууллагын удирдлага нь зөвлөлийн дарга, нарийн бичиг, гишүүдийн ажил үүргийн хуваарь, эрх үүргийг тодорхойлж, баталгаажуулсан байна.


Гишүүд:

- ❖ Ерөнхий мэргэжилтэн, алба, тасгийн эрхлэгч нарын төлөөлөл (амь тэнссэн үеийн тусламж, сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээ мэдээгүйжүүлэг, хүүхэд, эх барих, эмэгтэйчүүд, лаборатори, дотор, мэс засал)
- ❖ Сувилахуйн албаны дарга
- ❖ Эмийн мэргэжилтэн
- ❖ Эрүүл мэндийн газрын төлөөлөл (орон нутагт)

ЦСЗЗ-ийн үйл ажиллагаа

- 
- Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь гишүүдийн хурал байна.

- 
- Зөвлөлийн хурлыг улирал бүр, хяналт үнэлгээг хагас жил тутамд хийнэ.

- 
- Зөвлөл нь жилийн төлөвлөгөөгөө баталж, тайланг тухайн жилийн 12 дугаар сарын 25-ны дотор Цус сэлбэлт судлалын үндэсний төвд хүргүүлнэ.

ЦСЗЗ-ийн үүрэг

Цус, цусан бүтээгдэхүүн, цусны бэлдмэл, цус орлуулах шингэний хангамж аюулгүй байдлыг хариуцан ажиллана;

Эмнэлгийн тасаг, нэгжүүдэд шаардлагатай цус, цусан бүтээгдэхүүний хэрэглээг бүртгэж, хэрэгцээг жил, улирлаар тооцож гаргана;

Цус, цусан бүтээгдэхүүнийг зохистой хэрэглээ, цус сэлбэх эмнэлзүйн сайн дадлыг нэвтрүүлнэ;

Цус сэлбэх үйл ажиллагааг бүрэн баримтжуулан, хяналт үнэлэгээ хийж тасралтгүй сайжируулж ажиллана.

Лабораторийн тоног төхөөрөмжийн тохируулга, баталгаажуулалт, оношлуурын чанар, аюулгүй байдлыг ханган, чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрт тогтмол хамрагдаж ажиллана;

Зөвлөл нь эмнэлэг дэх Цусны нөөц зохицуулах нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

Эмнэлэгт хийгдэж буй цус сэлбэлттэй холбоотой үйл ажиллагаанд бүр дүн шинжилгээ хийж, сар улиралаар статистик мэдээллийг нэгтгэн баримтжуулна;

ЦЦБ-ий зохистой хэрэглээ, аюулгүй цус сэлбэлтийн талаар ажлын байрны болон богино хугацааны сургалтанд эмч, мэргэжилтнийг хамруулна;

Орон нутгийн ЦСЗЗ нь харьяалах сумдад цусны донорын бүртгэл, халдвар илрүүлэх, цусны бүлэг, хувийн тохироо тодорхойлох оношлуур, цусны хүүдийний нөөцийн бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллана;

Цус сэлбэлттэй холбоотой тулгамдсан асуудлыг эрүүл мэндийн газар, эмнэлгийн удирдлагуудад хүргүүлэн, шийдвэрлүүлнэ.

Зөвлөлийн бүрэлдэхүүний мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр дотоодын болон олон улсын хурал, семинар, сургалтад хамруулна.

Цусны нөөц зохицуулах нэгж

- Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай цус, цусан бүтээгдэхүүний нөөц хангамж, чанар, аюулгүй байдлыг хариуцана.
- Цусны нөөц зохицуулах нэгжид цус сэлбэлтээр мэргэшсэн эмч, сувилагч ажиллана.



- Тасгаас ирүүлсэн цус, цусан бүтээгдэхүүний захиалгыг авч нэгтгэн, ЦССҮТ-д илгээнэ.
- Цус, цусан бүтээгдэхүүнийг хүйтэн хэлхээний зөв нөхцөлд тээвэрлэнэ;
- ЦЦБ-ий хэрэглээтэй уялдуулан 7 хүртэл хоногийн нөөц бүрдүүлэн, нөхөн хангалт хийнэ;
- Хувийн тохироо тодорхойлох бүтээгдэхүүний гэзэг гуурсыг авч лабораторид илгээн, тохирсон бүтээгдэхүүнийг зөв өвчтөнд олгоно;
- Цус, цусан бүтээгдэхүүн хадгалж байгаа хөргөгч, хөлдөөгчийн хэмийг хоногт 3 удаа хэмжиж баримтжуулна.

- ЦЦБ-ий захиалга авах, хүргүүлэх, тээвэрлэх, эмнэлэгт хадгалах, лабораторид бүтээгдэхүүний дээжийг өвчтөний сорьцын хамт зөөвөрлөх, тасаг, нэгжүүдэд олгох, нөөцийг зохицуулах, сэлбэсэн бүтээгдэхүүний бүртгэх үйл ажиллагааг бүрэн баримтжуулж, архивлана;
- Бүлэг хувийн тохироо тодорхойлох урвал хүндрэл илэрсэн үед лавлагаа шинжилгээнд илгээх сорьцыг зөв авч, тээвэрлэн, ЦССҮТ-д хүргүүлж, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- Цус, цусан бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалттай холбоотой тулгамдсан асуудлыг эмнэлгийн удирдлагаар шийдвэрлүүлнэ;

- Эмнэлгийн цус сэлбэлтийг зохицуулах зөвлөлийг зохих бүрэлдэхүүнтэй байгуулж үйл ажиллагааг нь идэвхжүүлэх
- Тухайн эмнэлгийн өвөрмөц онцлогийг тусгасан цус захиалах хувиарийг боловсруулж, хянан засварлаж, мөрдөж ажиллах
- Цус сэлбэлтийн зохистой хэрэглээг хэвшүүлэхэд эмчлэгч эмч нар голлох үүрэг гүйцэтгэх

Анхаарал тавьсанд баярлалаа

Аюулгүй цус амьдрал бэлэглэнэ